



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/451

Булган сум

Хөгжимт жүжгийн театрын хэрэглэгдэхүүн,
материалын зардалд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай” А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хөгжимт жүжгийн театрын үзвэр, үйлчилгээний чанарыг сайжруулах, уран бүтээлийн цар хүрээг өргөжүүлэх, үзэгчдэд чанартай соёл, урлагийн үйлчилгээ үзүүлэх, техник тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор чадал, яригч, циркийн үзүүлбэрийн баг бүрэлдэхүүний зардал, төрийн далбаа, морь түрээс зэрэг шаардлагатай хэрэглэгдэхүүн, материалын зардалд 23,950,000 (хорин гурван сая есөн зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 26-ны/ний өдрийн
А/А9 дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн /төг/
1	2	3	4	5
1	Яригч	4ш	2,800,000	11,200,000
2	Чадал -7000	1ш	1,250,000	1,250,000
3	Цирк үзүүлбэр /10 минут баг, бүрэлдэхүүн/	-	5,000,000	5,000,000
4	Төрийн далбаа	100ш	35,000	3,500,000
5	Морь түрээс	60ш	50,000	3,000,000
Нийт дүн			23,950,000	